



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын 7.1.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХны:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн удирдах хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 321 дүгээр тогтоол, 2013 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн төслийн удирдах хорооны гишүүнийг чөлөөлж, томилох тухай 420 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.
2. Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн томилохыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга З. Нарантуяад зөвшөөрсүгэй.
3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА



000748